

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXV (367)

2012

(52-58)

“iru-a” ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРАЛ

М. Базаррагчаа *

Б.Я.Владимирцов авгай монгол бичгийн хэлний “iru~iruγā~iruwa~irwa” (знамение—бэлгэ тэмдэг, төлөг, ёр), знак (тэмдэг тамга, ул мөр, ёр бэлэг, дохио), предзнаменование (бэлгэ тэмдэг, зөн совин ёр) хэмээх үгийг алтай, хасаг, жаст зэрэг түрэг төрөл хэлнээ “irim” (сайн муу ёр), “irγ” (зөн ёр, аз заяа) гэж хэлэх ба ойрд аялгуунаа “jorō~irō, jor⁰” (ёр) гэж өгүүлдгийг харьцуулсан байна.¹

Г.И.Рамстедт “irua, iro” (jor⁰) хэмээх үгийг хиргэс, алтай, уйгур, хасаг зэрэг түрэгтэй төрөл нэг хэлнүүдийн “jora, угум, jōr-, jor-” (зөн ёр, мөрөөдөл, зүүд тайлах) гэдэг үгстэй харьцуулж, халимаг хэлнээ “jor|xɒ-” (iruala-), “jortši” (joryɒtši, jodyɒtši, sedžiktši) (iruači), “jory.otši” (бошиг үзүүлэгч, зөнч) үүнийг якут хэлнээ: “sorγu” (аз жаргал) гэж харьцуулжээ.²

Энэ үгийг Н.Поппе irwa<*irwa<*jürwa (зөн, ёр), Османы түрэг хэлнээ “jorum” (зөн) хэмээн харьцуулж, эхний “i” эгшгийн өмнө “j” гийгүүлэгч угтан ордгийг дээрх эрдэмтдийн адил тэмдэглэсэн байна.³ Ц.Д. Номинханов энэ үгийн тухай хэлэхдээ, “ёроор хэл-, ёрч, муу ёр, ёрло-, ёр хар-” зэрэг жишээ татаж, якут хэлнээ “irā, ira” (урьдчилан мэдрэх, зөгнөх, таах, аз жаргал) гэжээ.⁴

Энэхүү “iru-a” (ёр) гэсэн үг нь “iruγā” буюу “iruba” гэсэн эртний хэлбэртэй байсан ба сүүлчийн “a”-д өргөлт оногдон “u” эгшигтэй нийлэн, урт эгшиг үүсэх ёстой боловч зөвхөн “b,γ” гийгүүлэгч гээгдэж “i-ru-a” (ёр) гэсэн бичлэгээр хэвшигнэжээ. Энэ нь “činu-a” (činuγā, činuba) (чоно) гэснээс могол хэлнээ “činä” (чинаа) гэсэн хувилбар бий болсонтой ижил юм. Б.Я.Владимирцов “чоно” хэмээх үгийг “čīnwa~čīnuwa~čīnuγa~čīnw~čīnu”, (ёр) гэхийг “irwa~iruw~irwa~iruγa~iruγu~iru~irua” гэх мэтээр сэргээсэн⁵ ба Ховдын дөрвөдүүд “ёр”-ыг “jorō” гэж хэлдгийг тэмдэглэжээ. А.Мостайрт “энэ морь ёрдоо бяргүй байна, туулж ирэх ёргүй, энүүнийг унахыг байя”⁶ гэсэн жишээг ишилснээс үзвэл, “ёр” гэдэг нь “бяр чадал” гэсэн утгатай төдийгүй “бяр

* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

¹ Б.Я.Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Ленинград, 1929, стр.181, 204, 237, 379,

² G.J.Ramstedt. Kalmückisches wörterbuch, Helsinki. 1935, p.219

³ Nicolaus Poppe. Vergleichende grammatik der altaischen Sprachen. Teil I. Wiesbaden, 1960, p.32

⁴ Ц.Д.Номинханов. Материалы к изучению истории калмыцкого языка. Москва, 1975. стр.180

⁵ Б.Я.Владимирцов. Дурдсан зохиол. стр.248

⁶ A.Mostaert. Dictionnaire ordos, Tome deuxième (y-ž), Peking.1942, p.404a.

чадал” нь “зөн бэлгэд оршдог” гэсэн санаа давхар хадгалагдаж байна. Энэ салаа утгаас “ёрдох” гэвэл аливаа ажил үйлсэд хүч бяр гаргах”, “ёролхуу” гэвэл бяраар дээрэлхэх, тамирлаг” гэсэн утгатайгаас гадна “ёрын амьтан, ёрын үг, ёрын хүн, ёрын өвчин” гэхчлэн хэлэлцэх нь “муу, зэвүүцэм, жихүүцэм” гэсэн утгыг илтгэнэ. К.Ө. Голстунский “iruba, iru-a”(ёр), iru-a gōrūgēsū (ёр гөрөөс–араатны нэр, хятад хэлээр ‘минь-шоу’), iruba-či (ёрч), iručin, iruylči (предсказатель, гадатель- зөнч мэргэн) гэж тэмдэглэсний⁷ дотор “irūgēlči” (ерөөлч) гэсэн утга “iruā” хэмээх үгнээ нуугдаж байгааг олжээ. Үүнд: “iruba~iruā” хэмээх үгийн эр эгшиг нь эм эгшгээр сэлгэж, “irūgē” (ерөөх) хэмээх үг бүтсэн байна.

Э.В.Севортян “-ырым” (1. знак-тэмдэг, 2. средство лечения-эмчлэх хэрэглүүр, 3.надежда-итгэл, найдвар, химера-хоосон бодол, пустая мечта-хоосон хүсэл), 4.обычай, привычка-заншил зуршил) хэмээх үгийг “ырык, ырыз/ырыс” (тэмдэг, шинж, ёр, зөн, таамаг, хувь заяа, аз жаргал, төлөвлөх, мэргэлэх) гэсэн үгстэй харьцуулж, “-м” дагавраас үйлээс нэр бүтээх дагавар гэж үзсэн байна. Түрэгмен хэлний “ыр-” (ятгах өнгөрүүлэх) гэсэн үндэс нь монгол хэлний “iru-” хэмээх үндэстэй, “-м” нь “-ba~ya” -тай тус тус тохирох ба “ырык” (тэмдэг, хүсэл, хувь тавилан, зөвлөгөө, аз жаргал) гэдгийн “к” (q) нь “-m~b~γ~q” гэж сэлгэсэн бүтээврийн хувилбарууд байж болох юм. В.Банг, А.фон Габен нар “ir-” гэсэн үндсийг “yar-” (хагалах, бутлах) гэсэн үндэстэй холбосон ба Э.В. Севортян “iril” (ан цав үүсэх, урагдах), “irq-irim” (хонины шатаасан далан дахь ан цав гарснаар зөгнөн таамаглах) гэсэн анхны утгыг тайлсан байна.⁸ Ш.Цэцэнцогт, ‘iru~iru-a’ (ёр) хэмээх үгийг “сайн муу, бүтэх эсэхийн урьдаас сэрэгдэх бэлгэ тэмдэг гэж тайлбарлан бичиг зохиол дах жишээнээс хадаж, iruylčin, iruvačin, irula-, iručin, irūgē-, irūgēl, irūgēlči, irūgēr (l), irūgētū-, yoru (iru-a), yorula-, yoručin, irūgēn (хувь зохиол)⁹ гэснээс үзвэл “ёр” нь “ёрөө-, ерөөл” хэмээх үгтэй гарал нэг гэж үзсэн байна. Иймд “iruylči~irūgēlči” гэсэн хоёр үгийг К.Ө.Голстунский, Ш.Цэцэнцогт нар нэг гаралтай гэж үзсэн нь зөв юм. Цаашилбал, энэ үгс нь iruylar~ iruylal (ёроол), оууylar (оёор), Доод үдийн буриад аялгуунаа “irōr” (ёроол), Алайр буриад аялгуунаа “ojōr (оёор), Астраханы дөрвөд аялгуунаа “jorāl” (ёроол); irūgēr~ irūgēl (ерөөл), манж хэлнээ “firūren” (адис, ерөөл)¹⁰ хэмээх үгс нь гарал нэг болно. Г.И.Рамстедт irūgēl(ерөөл), irūgēdūn (ёрөөдөн)¹¹ гэсэн нэг үгийн хоёр хувилбарыг дурдсан ба харин ‘iruylar’ (ёроол) хэмээх үгийг түрэг хэлний “jurgaru”(сайн муу ёр), самоёд хэлний “iro/ilo” (сайн муу ёр), фин хэлний “rohja” (ёр зөн) хэмээх үгстэй харьцуулж, А.Позднеевын “Транскрипция палеографического текста” ‘Юань чао –миши’ бүтээлд “ōede irada”¹² (flussaufwaerts und flussabwaerts) гэсэн үгийг ишилжээ. Үүний “ōede” нь “ōgēde, irada” нь “iru-γāl-du” гэсэн үг бөгөөд “iru” гэдэг нь “iruylar~iruylal” гэдгийн “iru-“ ажээ. Ийнхүү “уулын ёроол, худгийн ёроол, далайн ёроол, савын ёроол” гэсэн үгсийн “ёроол” хэмээх үг нь “iru-a, irugē” (ёр, ерөөл) хэмээх үгтэй гарлаараа холбогдох ба үүнийг уйгар хэлнээ “jur, jir, jurg, ir” (зөн ёр), чуваш хэл (?) - ний “śar, śōr” (зөн ёр), зэрэг үгтэй М.Расенян харьцуулсан

⁷ К.Ө.Голстунский. Монгольско-русский словарь, том первый. С.Петербургъ, 1895, стр.141-142

⁸ Э.В.Севортян. Этимологический словарь тюркских языков (Общетюркские и межтюркские основы на гласные). Москва, 1974. стр.665-667

⁹ Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Жанг Жияа Кеү, 1988,310-311-рт.

¹⁰ Б.Я.Владимирцов. Дурдсан зохиол. стр.181-182

¹¹ G.J.Ramstedt. Дурдсан зохиол. p.220в.

¹² G.J.Ramstedt. Дурдсан зохиол. p.219в.

байна.¹³ К.Ө. Голстунский “*iruṡār-iruṡāl*” (ёроол) хэмээх үгийн утгыг “ёроолын амуу” (Остатки зерна на дне, подонки зерна въ магазине), ёроол мод (поперечныя подставки, подпорки, подкладки), ёроолын дэвээ (пороги на дне реки), ёроолын гэр (заднія зданія службы), чихний ёроол (дно уха, видимая внутренность уха) зэрэг жишээгээр үзүүлж, *irúgēr* (ерөөл) (пожеланія дурное и хорошее, благо отъ ролиденія, благоволеніе неба, счастье, благополучіе, молитва, молитвенное обращеніе), *iruṡār* (ёроол), (дно, исподъ, основаніе корень, центръ облавы) гэж тайлбарласан байна.¹⁴ Тэгвэл А.Мостайрт ордос хэлнээ “ерөөл”-ийг “өрөөл” (*öröl*) гэх ба “өрөөл омш-, өрөөл дурд-, өрөөл тавь-, өрөөл хувь, хараал өрөөл *irügēl* ~ *irügēr*” зэрэг жишээ татжээ.¹⁵ Энэхүү ‘ерөө-’ хэмээх үгийг монгол хэлэнд “*š-ürō*”, манж хэлнээ “*firu*” (ерөөх, мөргөх) эвенк хэлэнд “*hirugē*” (ерөөх), солонгос хэлэнд “*pil-*”(гуйх)¹⁶ гэж харьцуулснаас үзвэл, энэ үгийн эхнээ “s, h, p” гийгүүлэгч байсан ба “*irugē*” хэмээх үгийн “*ru*” гэсэн дэд үе –утгалбар нь “l” болж сэлгэсэн байна.

С.А.Старостин “*hiruṡār*” (*iruṡār*- ёроол) хэмээх үгийг түрэг хэлний “*jer*” (шал, хөрс) манж- түнгүүс хэлний “*pere*” (шал ёроол),(негидаль хэлнээ “*хеје*”, нанай хэлнээ “*pereg, perel*”, ульч хэлнээ “*pere(g)*”, орооч хэлнээ “*pereg, perel*”, эвенк хэлнээ “*here*”)-тэй гарал нэг гэж үзсэн ба түрэг хэлний “*jer*”, татар хэлнээ “*žir*”, узбек хэлнээ “*jer*”, уйгар хэлнээ “*јдр*”, чуваш хэлнээ “*šēr*”, якут хэлнээ “*sir*”, тува хэлэнд “*šer*”, хиргэс хэлнээ “*žer*” гэх мэтээр түгжээ.¹⁷

О.Ковалевский “*iruṡāci*” (ёрооч~ёрч) (гадатель, предсказатель)¹⁸ хэмээснийг “*irügēlci*” (ерөөлч), “*irügē*” (ерөөх)-тэй утга нэг байна гэжээ. Зөвхөн эр эм эгшиг сэлгэснээрээ ялгаатай байна.

Дээрх эрдэмтдийн гаргасан “*iru-*, *irü-*” хэмээх нөхөцмөл үндэс нь угтаа монгол хэлний “*qaru*-(харах-хусан тэгшлэх), *qaru-γül* (харуул), *kirüge* (хөрөө-огтлон таслах багаж), *kiru*-(хярах- махыг нарийвчлан хяргах, “*kirumčay*” (хярамцаг-малын гэдэс дотор, цус зэргийг гүзээнд нь хийж хөлдөөн, хэсэг хэсгээр хярж хэрчин идэх идэш) зэрэг үгийн эхний “q,k” гийгүүлэгч гээдэн үүсжээ. Энэ үгийн дэд үе-утгалбар дахь гийгүүлэгч эгшиг хоёрын завсар “b” гийгүүлэгч шурган орж, “*qa-r-bu-*” (харвах-онож эвдэх (алах), “*ke-r-bi-*” (хирвэх- жигд танаж хяргах), *ši-r-bi* (ширвэх- хэрвэх) зэрэг үүссэн байж болох ба “*kirṡa-*” (хяргах-жигд хирвэх), *kerči*-(хэрчих-огтлох), “*kira*” (уулын хяр), “*kiri*” (хир хэмжээ) зэрэг үг ч “*iruṡār*, *irügēr*” хэмээх үгтэй гарал нэг юм. Юу гэвэл, алив юмыг таслахад тасарсан хэсгүүд нь өөр өөрийн зах ирмэгтэй болж хир хэмжээгээ болон хил хязгаараа түүгээрээ ‘тогтоодог’ гэж болно. Иймд “*iruṡār*” (ёроол) нь “доод хязгаар”, “*irügēr*”(ерөөл) нь “дээд” (хүсэл сэтгэлийн) хязгаар гэсэн утга илтгэх болсон байна. Мөн энэ хоёр үгийн эхэнд сэлгэмэл “q-s” гийгүүлэгч байсан нь дээрх жишээнээс тодорхой биз ээ. Энэ сэлгэмэл гийгүүлэгч гээгдэж, үе–утгалбар задгайрсан, “*iruṡāi*” (особый родъ шелковичныхъ червей- торгоны хорхойн онцгой зүйл), “*irü-*

¹³⁾ Martti Rdsdnen. Versuch eines etymologischen wörterbuches der türksprachen, Helsinki, 1971, p 201b.

¹⁴⁾ К.Ө.Голстунский. Дурдсан зохиол. p.141-142

¹⁵⁾ А.Мостаерт. Дурдсан зохиол. p.539a

¹⁶⁾ Nikolaus Porre. Дурдсан зохиол. p.12

¹⁷⁾ С.А.Старостин. Алтайская проблема и пронохождение японского языка. Москва,1991стр.241, 281, 177

¹⁸⁾ О.Ковалевский Монголь-руско-французскій словарь, Томъ первый (а-ъ) Казань, 1844, стр.321

(1.зарыть-ухах 2.засыпать- асгах, булах, наполнить землею яму (газар нүхийг дүүргэх) 2. ir-(ирэх- хэт идсэнээс ходоод тэлэгдэх¹⁹, i-gū (объедаться, обжираться)²⁰, irγa-(яргах) (1.рыть нору, зарываться въ нору, 2.спорить, противиться, неуступать, (irγu) (яргах- нүд өвдөх) зэрэг үг ч ‘эвдэх’ гэсэн утгаараа “iru-, irū” хэмээх үндэстэй гарал нэг бөгөөд “kirγūi”(хяргуй- жижиг шувуудыг барьж иддэг нэгэн төрлийн махчин шувуу), “kirsā” (хярс-хулгана туулай зэргийг барьж иддэг үнэгтэй адилавар амьтан), ir (ир- хутганы ир), irmeg (ирмэг), irge (ирэг-хаяа), irgen (иргэн)²¹ зэрэг үг ч гарлаараа холбогдоно. Kirūge (хөрөө) хэмээх үгийг монгорт “tširū”, алайрын буриадад “s’ örö” буриадад “хүрөө” гэх ба манж түнгүүс хэлнүүдэд “siru, iregē, iregē~irebē, ire, siri, kirō; түрэг хэлнүүдэд ‘kirд, kirā, xirē, кдгд²²’ гэх мэтээр хэлдэг нь мөнөөх ‘iru-, irū’ гэх үндэстэй утга хэлбэрээрээ таарч байна. Харин ‘iruyār/l’ ёроол хэмээх үгтэй ‘oyuyār’(оёор) гэдэг үгийг нэг гаралтай²³ гэж үздэг боловч энэ oyuyūr (хэмээх) үг нь ‘kiḡayār’(хязгаар), Ыḡyūr (үзүүр), oḡyūr (озоор), uyḡyūr (ёзоор), iḡayūr (язгуур), qaḡayār (хазаар), siḡayūr (шазуур), siḡiyēr (шижээр), qoḡuūla (хожуул), keḡiyē (хэзээ), iḡaya (хэзээ язаа), kiḡayalang (хязгаалан), qaḡa-(хазах), keḡi-(хэжих), uḡayūr (узуур), seḡigyr (сэжүүр), seḡi-(сэжих) зэрэг үгийн дэд үе-утгалбар болох, ‘ḡa, ḡi’- гээс ‘ya, yu’-гээр сэлгэж үүсжээ.

Г. Д. Санжеев “d” нь “i”-ийн нөлөөгөөр “j” болж, улмаар “y” болон сэлгэдгийг “*edin-” (түрэг: idi, уйгар: (edi~ede)→ejin; jil→хойд буриад: jil; qadaγār→qaḡayār~kiḡayār (хазаар); ḡidkü→ хойд буриад: ḡitxə (зүтгэх); ḡasa- → хойд буриад: ḡahā- (засах), ойрд: ḡaḡa-(засах); дагуур: d’irγō~dzirγō, доод үдийн буриад: jirγōḡ, хойд буриад: joḡōḡ, дорнод буриад: zurḡāḡ, баруун буриад: žorḡōḡ (зургаа); gedeyi- (гэдийх)→geḡige (гээг); dolig (долиг)→ḡolig (золиг), adal (адал)→, aḡil (ажил); dam (дам)→ḡam (зам)→jam (ям); dergede (дэргэд)→ ḡerge (зэрэг), deleng(дэлэн)→манж:gelen→татар:džilin, узбек:jelin; aday (адаг- эцсийн)→хакас:azak, хиргис:ajak (хөл), azik (идэшний нөөц), алтай: azik (нөөц), тува:‘adak’ зэрэг жишээгээр баталсан байдгийг ‘kiḡayār, qaḡayār’ хэмээх үгтэй харьцуулна уу.²⁴

О.Н.Бётлингкийн тольд буй “харыи” (вскапывать-онгилох, пахать- хагалах), харыр (маленькая лопата-бяцхан хүрз)²⁵ хэмээх үг нь монгол хэлний ‘qaru-‘(харах-хусах), qaru-γül (харуул), kiru- (хярах), kirga-(хяргах) зэрэг үгтэй уг шаг нэг байна.

¹⁹⁾ Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 306-рт.

²⁰⁾ О.Ковалевский. Дурдсан зохиол, стр. 323

²¹⁾ М.Базаррагчаа. “irgen иγан” “qoyar qoyūsun” хэмээх үгсийн гарал, МУИС, “Монгол судлал” боть, Улаанбаатар, 2004, 159-173-рт

²²⁾ В.И.Цинциус. Параллельные синонимические ряды в языках алтайской семьи и их роль при сравнительно- историческом изучении лексики. “Алтайское этимологии”, Ленинград, 1984, стр.92

²³⁾ G.J.Ramstedt. Studies in Korean etymology. Helsinki.1949. p. 201.

Ш.Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Жанг Жияа Кеу, 1988, 303-рт.

²⁴⁾ Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Москва,1953, стр.99-117

²⁵⁾ О.Н. Бётлингк. О языке якутов. Новосибирск, 1989,1851, стр.528-529

В.И.Цинциус монгол хэлний “kirya-”(хяргах) гэсэн үгийг манж- түнгүүс хэлнүүдийн “cūkaqta, cūz`ahta, cūz`ūhta (*kūrgakta); иргакта~иргикта, ūrgat~ūrgāt (*ūrgakta); ийгакта. иза (*ирга), (соно, ногоон толгойт; бөхнө, хөх түрүү); түрэг хэлнүүдийн “qūq-, kirk-, kīrk-, гырк” (огтлох хайчлах); якут хэлнээ “кырг-, кырт-”(огтлох таслах) гэж харьцуулж, kirūi (хяргуй-махчин шувуу, начин шонхор) хэмээх үгийг ч гарал нэг²⁶ гэж тайлбарласан нь “irūyār, irgēg”-тай гарал нэг ажээ. Монгол хэлэнд “kirya”- ыг “tširya” гэж хэлдэг байна.

“Монгол хэлний тайлбар толь”-д “Домбо мэт сав суулганы амсартайгаа үргэлж задгай цоргыг хараа” (домбоны хараа, хөхүүрийн хараа (хөхүүрийн дэрвэгэр амсар): хүүхдийн өлгий дээрх нуман хэлбэртэй хориулыг хараа, монгол гэрийн тоононы голыг хараа, монгол гутлын оймсны гутлын түрийнээс дээш ил гарах хэсгийг хараа”(qaraγā)²⁷ залгаа зэрэг чимэглэл болох соновтрыг хараа (darayā) гэж тайлбарласныг үзвэл энэ үг нь “зах ирмэг” буюу “юмын гадаад талын хязгаар ирмэг” гэсэн утгатай нь бидний дээр өгүүлсэн “irūyār~irgēg” буюу, qaru- (харах), kiru-(хярах), kirya-(хяргах), ir (ир), ir- (ирэх- дүүрч үхэх) зэрэг үгтэй гарал нэг болох нь тодорхой байна. Уламлавал, энэ “qara-γā” хэмээх үгийн “qa-ra” гэсэн хоршмол үе-утгалбараас “qaraγāci~qariyāci (хараач-монгол гэрийн тооно буюу гэрийн дээд хязгаар зах), qariyācāi (хараацай хурц шовх далавчтай нүүдлийн шувуу), уйгур, түрэг хэлнээ: “karluγts, kalγats”²⁸ хурц ирмэг бүхий далавчтай учраас тийн нэрлэсэн байж болно), qariyācāi (хараацай яс-баруун зүүн мөрний ‘ирмэг бүхий’ яс), qarabci (хараач -хуягийн ханцуй, хуягийн хоёр талын зах хэсэг) зэрэг үг салбарлажээ. Энэ үгийн тэргүүн үе- утгалбарын ‘а’ эгшиг нь “у,ь” зэрэг эгшгээр сэлгэж, qurča (хурц – ирт мэсний даах чадал зэрэг), kīriyē (хүрээ) гэх мэт үг үүсжээ. Тэр ч байтугай “qara-(харах), qara (хар өнгө), qura-(хурах), кцгь-(хөрөх), kira-(хярах)” зэрэг үгтэй²⁹ алсуураа гарал нэг болно. Учир нь хүн тухайн дүрсийг ой тойндоо тогтоохдоо уг юмын гадаад ирмэгээр хурднаа тойруулан заагласнаа дотогш хураадаг жамтай ажээ. Иймээс ч энэ санаа гештальт сэтгэл зүйчид 1.юмсын гадаад хэлбэр 2.түүний бүтэц 3. юмын бүхэл дүрсийг тогтоодог³⁰ гэсэн үзэлтэй тохирох мэт санагдана.

Г.И.Рамстедт монгол хэлний “qaraγācāi”-г цагаадайн хэлнээ “qarča” гэж хэлдгийг тэмдэглэсэн нь “qurča” хэмээх үгтэй бүтцээрээ ижил юм.

Монгол хэлний “qurča (хурц), qariyācāi~qaraγācāi (хараацай), qarčiyāi~qarčaya (харцага), түрэг зүгийн хэлний ‘qarča’ (хараацай) тэлэнгэд, хасаг, хиргис, якут, цагаадайн хэлнээ “qarčiyāi” (харцагай)-г “qartyya, kurt”³¹ хэмээх үгтэй “огтлох, хэрчих-ир гаргах, хязгаар” гэсэн утгаараа нэг байна.

Мөн “tī~tu” гэсэн үе-утгалбар нь “-či~ču~ča” үе-утгалбар болон сэлгэдэг нь түгээмэл зүй тогтол юм. “qurča” (хурц) хэмээх үгийг алтай, тэлэнгэд, сартуул, хиргэс зэрэг алтайн салбар хэлнүүдэд “qurč, quruš, qөгөč” гэдэг байна. “qariyācāi”-г “qarādāi~qaraγādāi”(хараадай) гэнэ.

²⁶⁾ В.И.Цинциус. Дурдсан зохиол, стр 91

²⁷⁾ Монгол хэлний толь, Хөх хот, 1999, 1252-рт., Монгол хэлний тайлбар толь, Улаанбаатар 2011, 1409-рт

²⁸⁾ Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 974-рт.

²⁹⁾ М.Базаррагчаа. Монгол үгийн гарлыг мөшгөх нь., IV дэвтэр, Улаанбаатар, 1995, 230-266-рт

³⁰⁾ Р.С.Немов. Психологический словарь. Москва, 2007, стр87-88

Б.Г.Мещерякова, В.П.Зинченко. Большой психологический словарь. Санкт-Петербург, Москва, 2005, стр.99-100

³¹⁾ G.J.Ramstedt. Kalmückisches wörterbuch. Helsinki. 1935, p.170в,199в

Түрэг хэлнүүдэд “qarṣaγa”-ыг “карчыгай, картыга”, чуваш, башкир хэлнээ: “хурчāга, карсыга ~карсага” гэх ба Г.Дёрфер энэ үгийн “чы” нь монголд түрэг хэлнээс орсон гэдэг бол Л. Лигети, Г.Рамстедт, М.Расянян нар монгол хэлнээс гаралтай гэдгийг Л.С. Левитская, А.В.Дыбо, В.И.Рассадин нар тэмдэглээд, Д.Х. Базаров “кар” гэсэн дуу чимээний үгээс, Л.П.Петров, Н.И.Егоров нар “урах, маажих, ярах” зэрэг утгатай “qartī-, qarṣī-” үгээс үүсэлтэй³² гэж үзсэн байна. Тэгвэл “qaru- (харах, хусах), “tī-ta” –нь “таслах урах” “за” нь “салж бүтсэн юм” гэсэн утгаас ‘qar-ti-γa’ буюу ‘qarṣaγa’ хэмээх үг бүтжээ.

“Монголын нууц товчоон” дахь ‘Amin ele ṣinū bč’ēsь цlḡige tutum цkit qara’ū tutum qatut būi’³³ (Amin ele ṣinu bučēsь цlḡige tutum цkid qaraγū tutum qatud būi)³⁴ гэсэн өгүүлбэрийг Д.Цэрэнсодном “Өлжиг (суудал) тутам охид, Хараа (мухлаг) тутам хатад буй”³⁵ гэж хөрвүүлжээ. Энэ өгүүлбэр доторх “qaraγū” (харуу) хэмээх үгийг Ш. Гаадамба гуай ‘хар бүхээгтэй’ буюу ‘мухлаг бүрээстэй тэрэг’³⁶ ‘хар гуутай тэрэг’ гэсхийж утгачилсан бол Элдэндэй нар ба Д.Цэрэнсодном ‘дээрээ ямар нэг омог, хараа мэт дэрвэгэр бүрхүүл юмтай тэрэг’³⁷ гэж үзжээ. Энэ хоёр эрдэмтний тайлбарт буй ‘зах хязгаар ирмэг’ гэсэн санаа нь “iγuγār”(ёроол), iγγer (ерөөл), qaraγā (хараа- зах ирмэг) гэсэн үгийн утгатай таарч байна. Мөн “qara’ūn qabṣal, qara’ūn ḡidyn” гэсэн уулын нэрний тодотгол болсон “qara’ūn” гэсэн үг нь ‘хурц ирмэгтэй эгц элгэн хад хясаа’ гэсэн утгатай байж болох буюу ‘харж хусаж тэгшилсэн мэт эгц хад’-тай гэсэн утгатай мэт санагдана. Г.И. Рамстедтын тольд “qaruγū” (харуу төмөр)³⁸ гэсэн үг буй нь “qaru-” (харах хусах)-тай гарал нэг ажээ. Элдэндэй, Арджав нар “qaraγun ḡidun” нь өнөөгийн ‘Хянган даваа мөн гээд, “qaraγūn” гэгчийг “qarangqūi” “qab qara” гэсэн үг³⁹ гэж тайлжээ. “ḡidun” гэгчийг манжаар: ‘уулын нуруу’ гэсэн үг гэж тайлбарласан байна. Эртний монгол хэлнээ “ni” үе утгалбар “ḡi” “чи” нь “du”-тэй тус тус сэлгэх тул энэ хоёр үг угтаа нэг гаралтай юм. Жич, Г.Сүхбаатар “Нирун” гэсэн үгийг ‘жоужань’ (гүрвэлзэгч өт мэт)-тай “ni-ḡi”-гийн сэлгэцээр тайлсан байна.⁴⁰ Ш.Цэцэнцогт ‘qaraγuna’ (шувууны нэр) нь Далан хар уулын эртний нэр, Бодохул энэ уулнаа “харгуна” олон байсан бололтой⁴¹ гэжээ.

“iγu-a” (ёр) хэмээх үг нь ‘ёрын үг’ (сэжиг хүрэм үг), ёрын дуу (муу муухайг зөгнөсөн дуу), ёрын амьтан (бузрын амьтан), ёрын хүн (жигшин зэвүүцмээр, өөдгүй муу хүн) (Монгол хэлний тайлбар толь, УБ., 2011, 466-рт.), гэх мэтээр бэлгэгүй утгаар хэлэгдэх нь qariγā (хараах), qariγāl (хараал)~qaruγār (хараар- хараал) (уйгар, түрэг хэлэнд ‘kaγi’

³²⁾ Л.С.Левитская, А.В.Дыбо, В.И.Рассадин. Этимологический словарь тюркских языков. Обще тюркские и межтюркские лексические основы на буквы “к” “қ”. Москва, 1997. стр. 318

³³⁾ I.de.Rachewiltz. The secret history of the Mongols. Bloomington. 1971. p23

³⁴⁾ Элдэндэй Арджав. Монголын нууц Товчоон- сийрүүлэл тайлбар. 1986, Хөх хот. 93-рт

³⁵⁾ Д.Цэрэнсодном. Монголын нууц товчоо. Улаанбаатар, 2000, 38-рт

³⁶⁾ Ш.Гаадамба Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1990, 226-рт

³⁷⁾ Д.Цэрэнсодном. Дурдсан зохиол. 193-рт.

³⁸⁾ G.J.Ramstedt. Kalmückisches wörterbuch, Helsinki. 1935, p.171a.

³⁹⁾ Элдэндэй нар. Дурдсан зохиол. 551-рт.

⁴⁰⁾ Г.Сүхбаатар. Монгол нирун улс ба Монголын нууц товчоо.

“Монголын нууц товчоо”-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал” I дэвтэр, Улаанбаатар, 1995, 25-рт

⁴¹⁾ Элдэндэй нар. Дурдсан зохиол. 964-рт.

гэнэ) гэсэн үгс салаалах эх үүсвэр болжээ. Ийнхүү нэг үгээс эсрэг утга бүхий утга салаалахыг хэл шинжлэлд “энантиосемия (эсрэг утга)” гэх ба монгол хэлний ‘qariyā- (хараах), iḡgē- (ерөөх) гэсэн жишээ нь үгийн салаалан, холдон холдсоор ‘утга нь туйлширч’ эсрэг утгатай болдгийг харуулж байна. Нөгөө талаар ‘qariyā-, qariyā’ хараах гэсэн үг нь ‘эвдэх’ буюу ‘хусах, харах, харуулдах, ёроол’ гэсэн утга зонхилсноос ‘iḡge- (ерөөх)’ гэсэн утгаас ондоошин эсрэгцэх болсон байна.

РЕЗЮМЕ

В результате выпадения чередующихся согласных фонем “q~s” в начале однокоренных слов “qaru- (скоблить, скрести), kiri (мера, предел), qarbu- (стрелять из лука) kirbi- (ровно подстричь), kira (гребень), kiru- (мелко резать), qurca (острый, резкий), kirḡge (пила), kirya- (стричь), kerči (нарезать, разрезать) образуются слова ‘iruyār’ (дно) ‘irḡger’ (пожелание, желание блага), ir (острый край), irmeg (острый край), iru-a (предчувствие) дурное предзнаменование) со значениями “край, предел, удаляться, находиться вдали”. Когда отрежешь что-нибудь от чего-нибудь, появятся предел, острый край на обеих поверхностях предмета. Исходя из этого с помощью энантиосемии ответвляются слово “iruyār” (дно) с реальным значением и слово “irḡger” (пожелание) с абстрактным, в результате чего возникает слово “iruā” (ёр) что значит ‘дурное предчувствие’. Как нам кажется, слово “kira” гребень и “край” отрезок из одного происхождения.